

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 6 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 6 дугаар сарын ээлжит 9 дүгээр хуралдаанаар Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит байгууллагуудын үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлын тайлан сонсох тухай, Замын сангаас хөрөнгө шийдвэрлэх тухай, Боловсролын хуваарилагдаагүй зардлаас хөрөнгө шийдвэрлэх тухай, Нэрэмжит болгох, аймгийн “Хүндэт иргэн”-ээр өргөмжлөх тухай болон Төрийн одон медальд тодорхойлох тухай асуудлуудыг тус тус хэлэлцэж шийдвэрлэлээ.

Тулгар төрийн 2228 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 813 жил, Ардын хувьсгалын 98 жилийн ойн баяр наадам болон Баруун бүсийн зуны уралдааныг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, үүрэг чиглэл өглөө. Мөн Өлгий сумын 1 дүгээр цэцэрлэгийн анхны эрхлэгч, тус цэцэрлэгийн эрхлэгчээр тасралтгүй 25 жил ажилласан, төр нийгмийн зүтгэлтэн, сурган хүмүүжүүлэгч Мухайсын Булчин агсны 100 насны ойг тохиолдуулан Өлгий сумын 1 дүгээр цэцэрлэгийг түүний нэрэмжит болгож алдрыг нь мөнхжүүллээ.

Толбо сумаас Ховд-Өлгий чиглэлийн төв замд холбогдсон 4.5 км хатуу хучилттай хар замын засварын ажилд 15.0 сая төгрөг, Буянт, Алтай сумдын хоорондох замын засварын ажилд 15.0 сая төгрөг, Ногооннуур сумын Шар модны хадлангийн талбайн засварын ажилд 8.5 сая төгрөгийг тус тус замын сангаас зарцуулахыг зөвшөөрлөө.

Улаанбаатар хотод 2019 оны 6 дугаар сард зохион байгуулагдах Азийн урлагийн их наадамд аймгаа төлөөлөн оролцох төлөөлөгчдийн зардалд 2.0 сая төгрөгийг боловсролын хуваарилагдаагүй зардлаас хуваариллаа.

Аймгийн ИТХурал, Тэргүүлэгчдээс гарсан шийдвэр, зохион байгуулсан ажлыг аймгийн ИТХ-ын цахим хуудсаар тогтмол сурталчилж мэдээ мэдээллээр хангаж ажилласан. Аймгийн ИТХ-д нийт 46 албан бичиг ирж, хурлаас 38 албан бичиг холбогдох газарт хүргүүлэн иргэдээс 4 өргөдөл, гомдол ирж хянаж хариу өглөө.

1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Энэ сард Төрийн шагналаар шагнуулахаар тодорхойлсон Өлгий сумын нэг иргэний материалыг хүлээн авч танилцан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмын дагуу баримт бичгийг хянан шалгаж, материалыг Эрүүл мэндийн яаманд уламжлан ажилласан.

Орон нутгийн төрийн байгууллагын ажилтнуудын манлайллын чадавхыг бэхжүүлэх, тэдэнд шинэ санаа, сэдэл төрүүлэх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилго бүхий “Баян-Өлгий аймгийн төрийн албан хаагчдын манлайллын чадварыг бэхжүүлэх” сургалтыг 2019 оны 6 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд аймгийн ЗДТГ, Удирдлагын академи, Эрчим хүчний зохицуулах хороотой хамтран тус аймагт зохион байгуулав. Уг сургалтад аймгийн ИТХ, ЗДТГ, хэлтэс, агентлагийн дарга, мэргэжилтнүүд болон бүх сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга, сургуулийн захирлууд

болон эмнэлгийн дарга зэрэг нийт 250 гаруй ажилтан албан хаагчид оролцож мэдлэг, чадвараа дээшлүүлэн санал солилцов.

Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг, Үндэсний хөгжлийн газраас Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх бодлого боловсруулах зорилгоор Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн ЭТИС хөтөлбөр, Жайка ОУБ болон аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-д санал авах уулзалт, хэлэлцүүлгийг Баян-Өлгий аймагт 6 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан ба уг бүсчилсэн хөгжлийн бодлогод санал авах хэлэлцүүлэгт аймаг, сумдын удирдлагууд, салбар хариуцсан холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүд, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөлөл нийт 200 гаруй хүн оролцсон.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 46 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлөөс Баян-Өлгий аймгийн нутгийн захиргааны байгууллагын дарга, ажилтан, алба хаагч нарт зохион байгуулсан сургалтад аймгийн ИТХ, ЗДТГ, хэлтэс, агентлаг болон сумдын ИТХ-ын дарга, ИТХ-ын Нарийн бичгийн дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга нар зэрэг нийт 150 гаруй ажилтан, албан хаагчид хамрагдаж 2019 оноос шинээр хэрэгжиж байгаа Төрийн албаны тухай хууль болон түүнийг дагаж гарсан дүрэм, журмуудын талаарх ойлголтуудаа бататгав.

Энэ сарын 17-ны өдөр УИХ-ын дарга Г.Занданшатар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд иргэд, олон нийтийн оролцоог хангах асуудлаар 21 аймгийн удирдлагуудтай цахим хурал хийж, үүрэг даалгавар өглөө.

Цахим хуралд Баян-Өлгий аймгаас аймгийн ИТХ-ын дарга Д.Бауыржан, аймгийн Засаг дарга А.Гылымхан, ЗДТГ-ын дарга Х.Тилеген болон хэлтэс агентлагийн дарга, мэргэжилтнүүд, сургуулийн удирдлагууд, багийн Засаг дарга нар оролцлоо.

Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Дэлхийн банкны “Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх” төсөлтэй хамтран 2019 оны 6 дугаар сарын 19, 20, 21-ний өдрүүдэд Увс аймгийн Улаангом хотод зохион байгуулсан “Төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний уялдааг хангах нь” сэдэвт баруун бүсийн 5 аймгийн сургалтад тус аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд нийт 8 хүн хамрагдаж, 2019 оноос шинээр мөрдөгдөж эхэлсэн Төрийн албаны тухай хууль болон түүнийг дагаж гарсан дүрэм, журмуудын талаарх мэдлэгээ дээшлүүлэв.

Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 33-р зүйлийн 10 дугаар заалт, Дайчилгааны тухай хуулийн 28-р зүйлийн 1.2 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын аймгуудын Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу баруун бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл сургалт” 6 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд тус аймагт зохион байгуулагдав.

Сургалтад Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай зэрэг баруун таван аймгуудын сумдын ЗДТГ-ын дарга нар болон Цэргийн штабын бие бүрэлдэхүүн хамрагдаж Батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагаа, зорилго, зорилт, Зэвсэгт хүчний бүтэц зохион байгуулалт, батлан хамгаалах салбарын хуулиудыг орон нутагт хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын талаар мэдлэгтэй болов.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1. Санхүүгийн хяналт, аудитын албаны чиглэлээр

Тус алба нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан аймгийн БСУГазрын 2018 оны, аймгийн ЗДТГазар, Зооноз өвчин судлалын төв, Булган сумын бүх төсвийн байгууллагуудын 2017, 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт-шалгалт хийсэн ба заримыг нь дуусаагүй үргэлжлүүлэн шалгалт хийж байна.

Иргэдийн өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалтуудыг тухай бүр хийж байна.

Хяналт-шалгалт явуулж тавигдсан актын төлбөрөөс урьд оны үлдэгдлээс эхний 6 сарын байдлаар өссөн дүнгээр 1579.7 мянган төгрөг, энэ онд бичигдсэн актын төлбөрөөс 3757.8 мянган төгрөг, бүгд 5337.5 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулсан.

Энэ сард 4 төрлийн удирдамж боловсруулж, батлуулан хяналт-шалгалт хийж ажиллав.

Энэ сард 3 албан бичгийг хүлээн авч, хариутай бичгүүдэд хариу өгсөн ба 4 албан тоот бичиж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.

6-р сард хяналт-шалгалтын үр дүнгээр 15 төрлийн төлбөрийн акт тавигдаж, 1 төрлийн албан шаардлага хүргүүлсэн.

Албаны 2019 оны 6 дугаар сарын зарлага, санхүүжилтийн мэдээг хуулийн хугацаанд гаргаж, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст бичгээр хүргүүлж, шилэн дансны системд тухай бүр болон сар бүр оруулах мэдээллийг бүрэн оруулсан.

Нийгмийн даатгалын шимтгэл болон татварын тайланг хугацаанд нь гаргаж ажиллав.

ГУРАВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4.1. Эрүүл мэндийн чиглэлээр

Алтай, Сагсай, Цэнгэл, Улаанхус сумдын Эрүүл мэндийн төв, Хөх хөтөл, Хотгор багийн их эмчийн салбарт эрт илрүүлгийн хамрагдалт, бичиг хэргийн стандарт журам, эмийн чанар аюулгүй байдал, статистик мэдээ, мэдээлэл, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байдал, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, сургуулиудад нэмэлт дархлаажуулалтын хамралтын үнэлгээ хийсэн.

“Хүүхдийн эндэгдлийг бууруулах арга замыг тодорхойлох” хэлэлцүүлгийг Эрүүл мэндийн газраас харьяа эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарыг оролцуулан зохион байгуулж, хүүхдийн эндэгдлийн шалтгааныг хэлэлцэж, хүүхдийн тусламж үзүүлэхэд тулгамдаж буй асуудлаар санал солилцож, бууруулах арга замаа хэлэлцэж, зөвлөмж гарсан.

Батлан хамгаалах яам, Цэргийн төв эмнэлэг, аймгийн Засаг даргын газрын Цэргийн штаб, Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, хамтран эрүүл мэндийн салбарын 18 нэгжийн дарга, эрхлэгч нар, Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарт “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн асуудалд тулгарч буй бэрхшээл, түүнийг даван туулах арга зам, цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах тухай” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Эрүүл мэндийн сайдын 11 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор НЭМТ, ЗӨСТ-ийн мэргэжилтнүүд сумдын эрүүл мэндийн төвийн хүүхдийн эмч нарт

тарваган тахал өвчнөөс сэргийлэх ажлыг эрчимжүүлэх сэдвээр сургалт явуулж, 17 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан.

Цусны донорын дэлхийн өдрийг “Аюулгүй цус, цусан бүтээгдэхүүн хэнд ч, хаана ч” уриан доор тэмдэглэн өнгөрүүлж, 80 донорыг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.

Улаанбаатар хотоос ирсэн багш нар “Вирүст хепатитийн урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээний чадавх сайжруулах” сэдэвт 3 хоногийн сургалт зохион байгуулж, 87 эмч эмнэлгийн ажилтнуудыг хамруулсан.

Аймгийн ЭМГ-ын 35 ажилчныг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, үзлэг шинжилгээнд хамруулсан.

“Уралдаанч хүүхдийн аюулгүй байдал-Уяач таны хариуцлагаас” зөвлөгөөнд “Уралдаанч хүүхдэд учирч болзошгүй эрүүл мэндийн эрсдэлүүд” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх тасгийн ачаалал ихэссэнтэй холбоотой төлөвлөгөөт бус хяналт-шалгалт хийж, Нэгдсэн эмнэлэгт эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн дотоод халдвар гарахаас урьдчилан сэргийлэх, яаралтай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах албан тоот хүргүүлж зааварчилга өгч ажилласан.

Эх хүүхдийн дэмжих сангаас нэг жирэмсэн эх, нэг хүүхдийн зардлыг өгч гуравдугаар шатлалын эмнэлэгт шилжүүлж эмнэлгийн тусламж үзүүлсэн.

Аймгийн төвийн 10 айл, Улаанхус сумын 6 айлын худгаас ундны усны шинжилгээ авч аймгийн МХГ-ын лабораторид шинжлүүлсэн.

Зоонозын өвчин судлалын төвийн (ЗӨСТ) ажлын талаар

Хүний өвчлөлийн үед илрүүлсэн тарваган тахлын 2 үүсгэгчийг мөн хачигт халдварын хүн амаас дээжилсэн 37 хүний цусны ийлдсийг зохих журмын дагуу 3 суурьт савлагаагаар савлан, дагалдах бичиг баримтуудыг бүрдүүлэн цаашдын гүнзгийрүүлсэн шинжилгээ хийлгэхээр ЗӨСҮТөвд илгээсэн.

Онцгой байдлын ерөнхий газраас ирүүлсэн тарваган тахал өвчнөөс сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн Жансая, Шипагер, Рауан Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, тарваган тахал өвчний үед эрүүл мэндийн байгууллагаас авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ сэдэвт сургалт хийж, нийт 49 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан.

2019 оны 5-р сарын 14-нөөс 6-р сарын 2-ныг хүртэлх хугацаанд аймгийн төвийн болон голомтот бүс сумдын ЕБС-иудад тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалт хийж бага, дунд, ахлах ангиудын сурагчдыг хамруулан нийт 12690 сурагчдад мэдээ мэдээлэл өгч ажилласан.

2019 оны 6-р сарын 7-14-нийг хүртэлх хугацаанд Улаанхус сумын Шар булаг, Зуслан булаг, Талын толгой, Терискен тау, Худаг, Жаргалант Ногооннуур сумын Хаг зэрэг газруудыг хамруулан шимэгчгүйтгэлийн ажлыг ЗӨСТөвөөс 7 хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж 480 га талбайг хамруулан 810 нүхэнд шимэгчгүйтгэл хийв.

ДӨРӨВ. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР

1. АЛТАЙ СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын талаар

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архивын улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг томилж, байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгч ажиллан шалгалтын бэлтгэл ажлыг хангуулав.

6 дугаар сарын 11-нээс 12-ны өдрүүдэд аймгаас томилогдсон ажлын комисс тус суманд ажиллаж архивын улсын үзлэгийн бэлтгэл ажилд аргачлалын дагуу үнэлэлт дүгнэлт өгч, сумын хэмжээний бүх байгууллагууд хангалттай үнэлгээ авсан. Мөн архив, бичиг хэргийн үзлэгийн хамт аймгийн ЗДТГ-ын ХШҮнэлгээний хэлтсээс төлөвлөгөөт мониторингийн шалгалт явагдаж хангалттай дүгнэгдэв.

Мөн сумын 60 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ерөнхий комисс хуралдаж бэлтгэл ажлыг шуурхай ханган ажиллах талаар ярилцаж салбар комиссуудыг томилох, ард иргэдээс хандивыг ойрын хугацаанд цуглуулан дансанд оруулах талаар ажлын хэсгүүдэд үүрэг даалгавар өгөв.

Сумын хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлууд болон орон нутгийн татварын орлогын давсан хэсгээр хийгдэх ажлуудын тендерүүдийг зарлаж, хийгдэх ажлуудыг шуурхайлах үүрэг даалгавар өгч ажиллав.

Хот хоорондын зам буюу Буянт сумаас Алтай сум хүртэлх замыг засварлах ажлын төсвийг аймгийн Засаг даргад уламжлан хүсэлт тавьж аймгийн ИТХ-ын хурлын Тэргүүлэгчдээс замын сангийн хөрөнгөөс 15.000.000 /арван таван сая/ төгрөг хуваарилуулан тендерийг нь зарлуулан ажлаа эхлэхэд бэлэн болсон.

Мөн сумын төв стадионыг засварлах хөрөнгийг аймгийн ОНХСангийн хөрөнгөөс хуваарилуулан хийлгүүлэх ажлын тендерийг зарлаж шалгарсан компанитай гэрээ байгуулан гүйцэтгүүлэхэд бэлэн болсон.

Үндсэн хуулийн өөрчлөлт шинэчлэлтийн төслийн хэлэлцүүлэг тус сумд явагдаж аймгийн ИТХ-ын дарга, тус сумаас сонгогдсон ИТХ-ын төлөөлөгч нар оролцож төслийг танилцуулан ард түмний саналыг авч ажиллаа.

Энэ сард сумын Засаг даргын Хөрөнгө зарцуулах, Хүүхэд үрчлүүлэх, Зөвшөөрөгдөөгүй газарт худалдаа эрхлэхийг хориглох, Газар эзэмшүүлэх захирамжинд өөрчлөлт оруулах, Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн орчинд их цэвэрлэгээ хийлгүүлэх, Хагас жилийн түүвэр судалгаа явуулах, Үнэлгээний хороо байгуулах, Ажлын хэсэг байгуулах, БИНХурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах ажлын хэсэг байгуулах, Асран хамгаалагч тогтоох зэрэг 18 захирамж гаргаж биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Дээд газраас болон аймгийн ЗДТГ-аас 32 албан бичиг ирж цаг тухайд нь холбогдох албан тушаалтнуудад цохолт хийж хэрэгжилтийг хангуулан ажиллав.

Мөн Засаг даргын Тамгын газрын даргаас 13 албан тоот, Засаг даргаас 35 албан тоот явуулсан ба бүртгэлийн дэвтэр хөтөлж боловсруулсан, нийлсэн, хянасан стандартыг мөрдөн ажиллаж байна.

Иргэний 12 төрлийн бүртгэлийг өдөр бүр хөтлөн явуулж зохих хууль журмын дагуу гэрчилгээ олгож байна. 6 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар шинээр төрсөн 9 хүүхдэд төрсний гэрчилгээ олгож бичиг баримтжуулав. Тухайн сард шинээр гэрлэсэн 2 хосыг гэрлэлтийн бүртгэлд бүртгэв.

Шинээр иргэний үнэмлэх авах 15 иргэнийг мөн 25, 45 насны сунгалт хийлгэх нийт 10 иргэнийг шинэчилсэн бүртгэлд хамруулав. Иргэдийн гарт 18 цахим үнэмлэх олгож ИУБ- 21 маягт бичиж мэдээллийн санд оруулав. ИГББ-н бүртгэлийн мэдээг

ажлын 5 хоногт 2 удаа УБХ-т, тухайн сарын 25-ны мэдээг сумын ЗДТГ-т тайланг өгч ажиллав.

Нэрийн санд хаяг тусгах 32 хүүхдийн судалгааг нотлох баримт бүхий жагсаалтын хамт УБЕГ-т тогтоосон маягтаар хүргүүлж хаяг тусгуулав.

Засвар өөрчлөлтийн 11 материалыг нотлох баримт бүхий жагсаалтын хамт УБЕГ-т тогтоосон маягтаар хүргүүлж зохих залруулгыг тусгаж дахин олголтоор 4 хүүхдэд төрсний гэрчилгээ олгож ажиллав.

Хоёр. Хөдөө аж ахуйн үйл ажиллагааны талаар

Тус сумын 5 багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн нийлүүлгийн бус үед хуц, ухныг 4 суурь болгон маллуулахаар шийдвэр гаргаж сумын дүнгээр 709 хуц, 508 ухныг 4 суурь болгож маллуулан бруцеллэз өвчний шинжилгээнд бүрэн хамруулан баталгаажуулан ангилалт хийгдсэн.

Тус сумын мал сүргийг Малын индексжүүлсэн даатгалд хамруулах ажлыг 4-р сарын 1-ний өдрөөс эхлэн 6-р сарын 30-ныг хүртэл гүйцэтгүүлэв.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2008 оны 78 тоот тушаал болон аймгийн Засаг даргын 2019 оны А/226 тоот тушаал болон сумын Засаг даргын 2019 оны А/55 тоот захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор сумын хэмжээний ямаан сүрэгт үзлэг ангилалт хийв.

Тус сумын газар тариалан эрхэлдэг ААН, иргэд 1 га газарт төмс, 3 га газарт хүнсний ногоо, 15 га газарт ногоон тэжээл, 0,2 га газарт чацаргана тус тус тариалсан.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж буй техникийн судалгааг гаргаж аймгийн ХХАА-н газарт графикт хугацаанд хүргүүлсэн.

Сум хөгжүүлэх сангийн хагас жилийн мэдээг холбогдох маягтын дагуу гаргаж аймгийн ХХАА-н газарт хүргүүлэв.

Улсын хөрөнгө оруулалтаар 170,0 сая төгрөгийн хөрөнгөөр 100 га талбайд услалтын систем барьж ашиглалтад орох шатанд явж байгаа ба услалтын системийг хүлээн авах, бүртгэлд оруулах, цаашид хяналт тавих ажлын хэсэгт орж хяналт тавин ажиллаж байна.

Гурав. Байгаль орчны хяналтын үйл ажиллагааны талаар

Бага эрсдэлтэйгээр үнэлэгдсэн бүрэн дунд сургууль, хүүхдийн цэцэрлэг зэрэг 2 албан байгууллагыг хамруулан батлагдсан хяналтын хуудсаар шалгалт хийж үнэлэгдсэн эрсдэлийг бууруулах илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоо бүхий 10 заалттай 2 зөвлөмжийг хүргүүлэн зөвлөн туслах үйл ажиллагааг үзүүлсэн болно.

Энэ сард аргал, угалзын тооллогыг хийхэд Халуунд 53 аргаль, угалз, 6 хурга, Шарговьд 17, Даваатад 18, Цалгарт 8 аргаль, угалз тус тус хаваржиж байна.

Хууль бус агнууртай тэмцэх зорилгоор загастай голуудад тавигдах эргүүл хяналт-шалгалтыг тогтмолжуулан ажиллаж байна.

Дөрөв. Газар зохион байгуулалтын үйл ажиллагааны талаар

Сумын нутаг дэвсгэрт газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын газрын төлбөрийг хуулийн дагуу ногдуулж сумын төсөвт төвлөрүүлж байна.

Шинээр газар эзэмшүүлэх тухай 4 өргөдөл, газрын маргаантай 1 иргэний өргөдөл, ᠔᠘ᠶᠦᠳᠡᠳᠡᠭ тус тус ᠔᠘ᠶᠦᠶᠦᠰᠡ бүртгэж, өвөлжөө, хаваржааны зориулалтаар 3 иргэний эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх Засаг даргын захирамжийг үндэслэн газар эзэмших гэрээ байгуулж гэрчилгээ олгов.

Тус сард 11 иргэний нэгж талбарын хувийн хэргийг ЛМ2 программд оруулан цахимд архивлав.

Тав. Боловсролын талаар

Боловсролын үнэмлэх, гэрчилгээнд тавигдах дүн /Б маягт/ болон төгсөгчдийн баримт бичиг бичих эрх зүйн актуудыг / сайдын тушаал/-ыг төгсөх ангийн багш нарт танилцуулав.

Ангиудын хувийн хэргийг багш нарт өгч тооцоо хийж, сургуулийн архивт хүлээж авсан.

Бага ангийн багш нарт компьютерийн сургалт явуулав. Мөн мэдээллийн системд сурагчдын дүнг оруулж, системд шинэчлэл хийв.

Сургуулийн 2019 оны эхний хагас жилийн тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллав.

Эх үрсийн баярыг тохиолдуулан хүүхдүүдийн дунд уралдаан тэмцээн зохион явуулж эцэг эхчүүдийг оролцуулав.

Алслагдсан багуудын зусланд нүүдлийн бүлэг гаргах хуваарь гаргаж хуваарийн дагуу Харнуур, Цалгар, Рашаант зусланд нүүдлийн бүлэг гаргаж байна.

Зургаа. Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны талаар

Жирэмсний хяналтад шинээр 3 эхийг авсан ба одоо хяналтад 47 эх байна. Өртөмтгий эмзэг бүлгийн жирэмсэн эхийн тоо 11, жирэмсэн болон төрсөн эхэд 61 удаа гэрийн идэвхтэй эргэлт хийсэн.

Эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдах ажлыг эрчимжүүлсэн ба хөхний өмөнгийн үзлэгт 217 хүн, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт -7 хүн, АГ,ЧШ –ийн үзлэгт 150 хүнийг тус тус хамруулсан.

Товлолын дагуу вакцинжуулалтад хамрагдах хүүхдийн нэрсийг баг тус бүрээр гаргасан ба , тухайн сард хамрагдвал зохих 51 хүүхдээс 47 хүүхдийг вакцинжуулалтад хамруулсан.

2. ТОЛБО СУМ

Нэг. Удирдлага зохион байгуулалт, хууль, эрх зүйн чиглэлээр

Сумын ЗДТГ-ын сурталчилгааны самбарт долоо хоног бүр мэдээллийн самбар ажиллуулж, иргэдийн сонирхсон асуудлуудын талаар зөвлөгөө өгч ажиллахыг хэвшил болгов.

Дээд байгууллагаас ирсэн албан бичгийн хариуг цаг хугацаанд нь өгч, иргэдээс ирсэн өргөдлийг цаг хугацаанд нь шийдвэрлэж байна.

Улсын бүртгэлийн мэдээлэл:

№	Бүртгэлийн нэр	Тухайн сард хийсэн бүртгэл
1	Төрсний бүртгэл	17

2	Үрчилсний бүртгэл	0
3	Овог, эцэг\эх\-н нэр, нэр өөрчилсний бүртгэл	0
4	Гэрлэлтийн бүртгэл	1
5	Нас барсны бүртгэл	3
6	Иргэний үнэмлэх олголт	32
7	Шилжин явсны бүртгэл	12
8	Шилжин ирсний бүртгэл	10
9	Шинэчилсэн бүртгэл \хурууны хээ\	22
10	Иргэний үнэмлэх дахин олголт	4

Хоёр. Боловсролын талаар

Анги дэвших шалгалтыг 18 судлагдахуунаас авч, улсын шалгалтыг заасан хугацаанд журмын дагуу авч анализ хийж, үр дүнг тооцов.

Системд шилжиж ирсэн сурагчдын дүнг нөхөн оруулав.

Суурь боловсролын гэрчилгээг нийт 72 сурагч, бүрэн дунд боловсролын гэрчилгээг 49 сурагчдад гардуулан өглөө.

Хувийн хэргүүдийн хөтлөлтөд хяналт тавьж засвартай бичиг баримтуудыг дахин шинэчлэн янзлав.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр

6-р сард нийтдээ 32 хүн хэвтэн эмчлүүлсэн ба амбулаторын үзлэг 182, ор хоног 121, халдварт бус өвчний үзлэг 64, артерийн гипертензийн үзлэг 60 хүн, чихрийн шижингийн үзлэг шинжилгээнд 60 хүн, хөхний өмөн илрүүлэх үзлэгт 80 хүн, умайн хүзүүний өмөн илрүүлэх эсийн шинжилгээнд 9 хүнийг тус тус хамруулав.

Энэ сард дархлаажуулалтад 40 хүүхдийг хамруулав. Нийт төрөлт 6, үүнээс аймагт 3, суманд 3 хүн эсэн мэнд амаржсан.

Шинээр хяналтад 9 эх орсон ба хожуу хяналтгүй байна.

Одоо жирэмсний хяналтад 58 эх хянагдаж байгаа ба үүнээс эрсдэлтэй бүлгийн жирэмсэн эхийн тоо 9 байна.

НДС-гаас үнийн хөнгөлөлттэй эмийг 30 хүнд олгосон.

Цусны ерөнхий шинжилгээнд 31 хүн, шээсний шинжилгээнд 42 хүнийг хамруулав.

Дөрөв. Хөдөө аж ахуйн чиглэлээр

Энэ сард цаг агаар сарын эхний 4 долоо хоногт тогтуун байсан ба сарын сүүлчээр хүйтэрч бага зэргийн хур тунадас орж хүйтэрч төл бойжилтод хүндрэл учруулсан.

Мал төллөлт 89 хувьтай байгаа ба бог малын 97-99 хувь нь төллөж төл бойжилт 99,2 хувьтай байна.

Энэ сард малын халдварт өвчин гараагүй, малын эмч нар төл бойжуулах үеэр малчин түмэнд ойр ажиллаж, малын эмээр ханган ажиллав.

Одоогоор 234 толгой том малын, 533 толгой төлийн хорогдолтой байгаа ба 150 ямаа хээл хаясан мэдээтэй байна.

3. БУЛГАН СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Сумын 2019 оны Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлуудын зураг, төсвийг хийлгүүлэн арга хэмжээ авч ажиллаж байна.

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн талаар ард иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлтийн ажлын талаар танилцуулах зорилгоор аймгийн Засаг дарга тус суманд ирж ажиллаж, сумын ард иргэдтэй уулзалт зохион байгуулав.

Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Сумын төсөвт 9 байгууллага бүгд 5 сарын санхүүжилтээ авч дууссан ба нийт 2,065,717,9 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Сумын орон нутгийн орлогод нийт 92271,8 мянган төгрөг орсон.

Орон нутгийн орлогыг оны эхнээс төрөл бүрээр нь биелүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

Гурав. Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд

Хөдөө аж ахуй, мал аж ахуйн хувьд бороо хуртай хэвийн зуншлага болж байна. Төл бойжилтын мэдээгээр 38514 толгой эх мал төллөж, 35098 толгой төл бойжиж, 3416 толгой төл хорогдсон. Зүй бусаар хорогдол 4168 толгой байна. Газар тариалангийн хувьд төмс 16,2 га-д, олон настын ургамал 0,5 га-д, лууван 0,75 га-д, манжин 0,55 га-д, сонгино 0,1 га-д, өргөст хэмх 0,5 га-д, жимс 7,5 га-д тус тус тариалсан мэдээтэй байна.

Дөрөв. Үйлдвэрлэл, үйлчилгээ, эрчим хүч, дэд бүтцийн бодлогын хүрээнд

Тус сумын үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн ажил хэвийн явагдаж байна. Цахилгаан шугам тасралтгүй хэвийн ажиллаж байна.

Тав. Эрүүл мэнд, спортын талаар

Тус сумын Эрүүл мэндийн төвд 8 эх амаржиж, 8 хүүхэд эсэн мэнд бойжиж байна. 8 эхийн төрөхийн ор хоног 55 ор хоног байна. Жирэмсний хяналтад 88 эх байна. Тухайн сард нас барсан хүнгүй байна. Сумын эрүүл мэндийн төвд 86 хүн хэвтэж эмчлүүлсний ор хоног 416 ор хоног байна.

Халдварт бус өвчлөл 55 гарч, 254 хүн шинжилгээ хийлгэсэн. Түргэн тусламжийн дуудлага 105 гарснаас алсын дуудлага 97 байна. Нийт үзлэг 1474, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 389, амбулаторын үзлэг 473 ба вакцинжуулалтад 154 хүүхэд хамрагдсан.

4. САГСАЙ СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн бодлогын хүрээнд

Багуудын ИНХ-ыг зохион байгуулж, ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудыг оролцуулав. Хурлын үеэр малчдын зусланд гарах, намаржаа болон хадланд буух хугацааг тогтоож, хадлан, газар тариалангийн газар, өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малын хөлөөс чөлөөлөх, хадлангийн талбайн хамгаалагчийг томилох, 2020 онд ОНХСанийг хөрөнгөөр баг бүрээс хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэлэлцэж эрэмбэ дарааллыг тогтоох зэрэг асуудлыг авч хэлэлцэн, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллав.

Сумын Засаг даргын захирамжаар Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын дагуу сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан ОБГазарт хянуулахаар хүргүүлэв.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ээлжит улсын үзлэгийн урьдчилсан үзлэг хийх аймгийн салбар комисс сумд ажилласан ба Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, Байгууллагын архивын ажил, Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, цахим сан бүрдүүлж буй байдал зэрэг 4 чиглэлээр үзлэг явуулснаас ЗДТГ 96.2 %, ЕБ-ын 1 дүгээр сургууль 80.8%, Хүүхдийн цэцэрлэг 77.7%, Эрүүл мэндийн төв 70.6%, Соёлын төв 59%, ИТХурал 62.8 %-иар тус тус үнэлэгдлээ.

Дэлхийн Зөн Монгол ОУБ-аас сумын зорилтот 4 өрхөд өрх бүрт 3 тугалтай үнээ олгож дэмжлэг үзүүллээ.

Сумд 2020 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бүтээн байгуулалтын ажлын жагсаалтыг гаргаж, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэст хүргүүлэв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих сумын төвийн асфальт зам, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих Үзэгчдийн сандал, Ковш трактор, Хүүхэд, залуучуудын паркны их засвар зэрэг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч, нийлүүлэгч сонгогдсон бол стадионы засварын ажил эхэлж, ажлын явцтай орон нутгаас тогтмол хяналт тавин ажиллаж байна. Даянгийн хүүхдийн цэцэрлэгийн барилгын засварын ажил гүйцэтгэгчийг сонгох шатанд байна.

Аймгийн Цэргийн штабаас зохион явуулсан дайчилгааны бэлтгэл нөөцийн 14 хоногийн сургалтад 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн 5 иргэнийг хамруулж мэргэжлийн гэрчилгээтэй болголоо.

Малчид, иргэдийг мөс цөмрөх аюулаас болон шар усны үерт автахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн ОБГ-ын даргаас өгсөн үүргийн дагуу суманд арга хэмжээ авч хэрэгжүүлэн аймгийн ОБГ-т тайлагнав.

Сум байгуулагдсаны түүхэн 60 жилийн ойн бэлтгэлийн ажлын хүрээнд ойн тэмдгийг бэлэн болгох, урилга тараах зэрэг ажлууд хийгдэж, аймаг дахь Нутгийн зөвлөл хуралдаж сумын төвд 30.0 сая төгрөгийн үнэ бүхий Дурсгалын хөшөө босгохоор шийдвэрлэлээ.

Холбогдох эрх зүйн акт болон бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг нэгтгэн гаргаж аймгийн ЗДТГ-т хүргүүлэв.

Нотариатын үйлчилгээг 79 иргэнд үзүүлж, тэмдэгтийн хураамжид 113,680 төгрөг оруулав.

Иргэдээс ирсэн 19 төрлийн өргөдөл гомдлыг хүлээн авч, барагдуулах ажил зохион байгуулав. Ирсэн 37 бичгийг бүртгэж түүний мөрөөр ажил зохион байгуулж, 26 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэв. 15 төрлийн хугацаат албан бичгийг хүлээн авч түүний мөрөөр ажил зохиож хариуг хугацаанд хүргүүлсэн.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсөвт байгууллагуудад 6 дугаар сарын төсөв бүрэн ирснийг холбогдох зардлын зүйл ангиудад хуваарилан зарцуулсан. 398,479,300 төгрөгийн 231 төрлийн гүйлгээ хийгдсэн. 6-р сард 283 901 300 төгрөгийн санхүүжилт орсон.

2,426,000 төгрөгийн татварын орлого оруулсан ба хадгаламжийн хүү 1,172,000 төгрөг байна.

Төсөвт байгууллагуудын НДШ, түлш халаалт, тээвэр шатахуун, гэрэл, ХХОАТ, албан томилолт, цалингийн өр бүгд 137,464,700 төгрөг байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хугацаа хэтэрсэн 10 иргэнийг шүүхийн байгууллагад шилжүүлсэн. Нийт 79,0 сая төгрөг.

Гурав. Хөдөө аж ахуй, газар тариалан, байгаль орчны бодлогын хүрээнд

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бод 5612, бог 43048, бүгд 48660 толгой мал хамрагдаж вакцинжуулалт 99,5% хийгдсэн байна.

Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх 3 төрлийн арга хэмжээнд бүгд 85708 толгой мал хамрагдаж, сэргийлэх арга хэмжээ 97,3%-тай хийгдсэн.

Ариутгал халдваргүйжүүлэлтийг малын хашаа, саравчийг хлорын шохой, экоцид, вирконыг шүрших аргаар 106072 м² талбай, бэлчээр 12826м² нийт 118898м² талбайд хийж гүйцэтгэсэн.

МЭТасагт малын эмч, малчдаас ирсэн 4 дуудлагад очиж газар дээр нь онош тавьж ажиллав. Ямар нэгэн халдварт өвчин гараагүй болно.

Малын шилжилт хөдөлгөөнд байнга хяналт тавьж гарал үүслийн гэрчилгээ олгож бүртгэлд оруулж ажиллаж байна. Одоогийн байдлаар 48 гарал үүслийн гэрчилгээ бичигдэж 202 толгой малд олгосон байна.

Нийт зүй бус том малын хорогдол 2117. Үүнээс адуу 91, үхэр 193, хонь 906, ямаа 927 толгой мал хорогдов. Хээл хаясан малын тоо 564. Үүнээс ямаа 512, гүү 49, үнээ 3 байна. Нийт 77653 хээлтэгчээс 70519 хээлтэгч мал төллөсөн. Үүнээс 68668 төл бойжсон байна. Нийт 1851 төл хорогдсон, мал төллөлт 90.8%-тай байна.

Энэ жилийн тариалангийн эцсийн мэдээгээр төмс 20,6 га, хүнсний ногоо 5,3 га, чацаргана 11 га, малын тэжээл 110 га талбайд тус тус тариалсан.

Дөрөв. Боловсрол соёл, шинжлэх ухааны талаар

9 болон 12-р анги төгсөх сурагчдаас монгол хэл, математик, казах хэл, химийн болон бусад хичээлүүдээс шалгалт авлаа. 9 болон 12-р ангийн сурагчдын аттестат гэрчилгээг шинээр бичиж, яамны үнэлгээний төвд явуулав. Нийт 12-р ангийн 80 сурагч, 9-р ангийн 90 сурагчдад аттестат гэрчилгээг хэвлэн, аймгийн БСУГ-ын даргад хянуулан ямар нэгэн зөрчилгүй бичиж, сурагчдад тараав.

Дотуур байр, гал тогоонд засвар хийж байгаа ба анги удирдсан багш нар өөр өөрсдийн ангид засвар хийж байна.

Бүх багш нар 6-р сарын 17-ноос амралт авсан.

Тав. Эрүүл мэнд, спортын талаар

Энэ сард 6 эх хөнгөрсөн. Эмнэлэгт 39 хүн 273 ор хоног хэвтэн эмчлүүлсэн. Вакцинжуулалтад 80 хүүхэд хамрагдсан. Одоо 90 жирэмсэн эх хяналтад байна. Эх, хүүхдийн эндэгдэл гараагүй. 57 удаа түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлсэн.

5. ДЭЛҮҮН СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Багийн иргэдийн нийтийн хурлыг баг бүрт нэгдсэн журмаар зохион байгуулж зусланд гарах, эцэг малыг тусгаарлах, хадлангийн сахиул ажиллуулах болон бусад асуудлуудаар иргэдийн санал бодлыг сонсож зохих шийдвэр гаргасан.

Үндсэн хуульд оруулах иргэдийн санал, хүсэлтийг нэгтгэн авч аймагт хүргүүлэв.

Азийн хөгжлийн банкны судалгааны багийн шаардсан орон нутгийн хөгжилтэй холбогдолтой судалгаануудыг гаргаж хүргүүлэв.

Архивын улсын үзлэгийг угтаж архивт 2017 он хүртэлх баримтыг тушааж, аймгийн ЗДТГазраас явуулсан үзлэгт хангалттай сайн үнэлгээ авсан ба цаашид байгууллагын түвшинд нэмж хийх ажлуудыг гүйцэтгэж байгаа болно.

Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн бодлогын хүрээнд

ЕБС-д 466196,5 мянган төгрөгийн санхүүжилт авч 384613,9 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан. ЕБС-ийн хувьд түлш халаалтын өртэй гарсан ба цалингийн зардал дутуу батлагдсан учир цалин болон НДШ, ХХОАТ өр гарч байна. ЗДТГ-ын хувьд 31370,1 мянган төгрөгийн санхүүжилт авч 31156,6 мянган төгрөгийг зарцуулсан. ИТХ 4636.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 4676,5.3 мянган төгрөгийг зарцуулсан. Сургуулийн өмнөх боловсрол 63993,2 мянган төгрөгийн санхүүжилт авч 73455,4 мянган төгрөгийн төгрөгийг зарцуулж өр, авлагагүй ажиллаж байна. Эрүүл мэндийн салбар 56243,2 мянган төгрөгийн санхүүжилт авч 59169,8 мянган төгрөгийг зарцуулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төлөвлөгөөг “Шилэн дансны” систем, дундын сүлжээнд байршуулж байна.

Сумын мэдээллийн самбарт зарлал, төлөвлөгөө, гүйцэтгэлийг байнга байршуулан ажиллаж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Энэ сард гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл бүртгэгдээгүй ба шалгагдсан эрүүгийн хэрэг байхгүй байна.

Тухайн сард замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн нийт 4 жолоочийг 1,000,000 төгрөгөөр торгож, 1 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хасаж, 1 жолоочийг шүүхээр 8 хоногоор баривчлуулахаар шийдвэрлэсэн.

Нийтийн хэв журмын эсрэг зөрчил гаргасан 3 хүнийг 450,000 төгрөгөөр торгов.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

ДЗОУБ-аас ядуу, нэн ядуу өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор дугуй засвар, оёдол, дархан мужаан зэрэг төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн.

Хүүхэд үрчлэлттэй холбоотой иргэдийн өгсөн өргөдлийг судалж холбогдох хуулийн хүрээнд дүгнэлт гарган ажиллаж байна.

Сум дундын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч 85 хүн, ор хоног 556, үзлэг 1573, төрөлт 1 эх, нас баралт 4 хүн байна. Эх, хүүхдийн эндэгдэл гараагүй болно.

Вакцинжуулалтын хамрагдалт 97,1%-тай байна.

6. УЛААНХУС СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Сумын багийн иргэдийн нийтийн хурлыг 6 сарын эхнээс 11 багийн хэмжээнд зохион байгуулж зусланд гарах, хадланд буух асуудлыг багийн иргэдтэй хэлэлцэж батлав.

Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор сумын Засаг даргын 2019 оны А\90 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг сумын хэмжээнд байгууллагуудын дарга эрхлэгч, бичиг хэргийн ажилтнуудад Улсын үзлэгт бэлдэх заавар, зөвлөгөө өгч ажиллав.

6-р сарын эхэнд архивын улсын үзлэгийг угтаж аймгийн архивын тасгийн ажлын хэсэг сумын албан байгууллагуудад урьдчилсан үзлэг хийсэн. Сумын нийт 11 байгууллагын архив, бичиг хэргийн стандартыг шалгаж, дөрвөн чиглэлээр дүгнэж, илэрсэн алдаа дутагдлуудыг арилгаж улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангаж ажиллах талаар үүрэг даалгавар өгч, ажиллав. Сумын хэмжээнд улсын үзлэгийн бэлтгэл ажлыг “сайн” гэж дүгнэсэн.

Төрийн албаны зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсэг 6 сарын 14-ний өдөр тус суманд ажиллаж, Тамгын газрын үйл ажиллагаатай танилцаж, төрийн албан хаагчидтай уулзаж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв.

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэж байгаатай холбогдуулан иргэдэд нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлэл өгөх, санал бодлыг сонсох зорилго бүхий уулзалт хэлэлцүүлгийг Улсын Их хурлын Г.Солтан гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг 6 сарын 21-ний өдөр тус сумд зохион байгуулж, иргэдийн саналыг нээлттэй хүлээн авч, иргэдээс маягтын дагуу санал авч ажиллав.

Сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж сумын хэмжээнд Тээврийн хэрэгслийн үзлэгийг 2019 оны 6-р сарын 2-ны өдрөөс 6-ны хооронд зохион байгуулсан. Тээврийн хэрэгслийн үзлэгт нийт 528 машин хамрагдсан, 14,531.4 мянган төгрөгийн татварын орлого, агаарын бохирдлын төлбөр 2,700.0 мянган төгрөг тус тус орсон болно.

6 дугаар сард сумын Засаг даргаас нийт 9 захирамж гарсан. Засаг даргын Тамгын газрын даргаас 2 тушаал гарсан байна.

Тамгын газарт бусад газраас 20 бичиг ирсэн ба үүнээс 13 хариутай, 7 хариугүй бичиг байна. Сумын Засаг даргын Тамгын газраас бусад газарт 20 бичиг явуулав.

Иргэдээс Тамгын газарт 27 өргөдөл хүлээн авч, Засаг даргад танилцуулан холбогдох албан тушаалд хүргүүлэн хариуг эзэнд мэдэгдэж байв.

Хоёр. Байгаль орчны талаар

Байгалийн түгээмэл тархацтай ашигт малтмал болох элс, хайрга, шар шавар ашиглан иргэдэд үйлчилж байгаа ачааны машинтай жолооч нарт хурал хийж, сум орон нутгаас гарсан тогтоол шийдвэрүүдийн талаар ойлголт өгч, зохих хууль журмын дагуу байгалийн баялгийг ашиглах, төлбөр хураамжийг хугацаанд нь Тамгын газрын төрийн сангийн дансанд хийж хэвших талаар зөвлөгөө өгөв.

Хогийн цэгийн судалгааг гаргаж аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэв.

Гурав. Газрын харилцааны талаар

Тус сумд сумын төвийн ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаатай холбогдуулан төлөвлөгөөтэй холбоотой санал болон газрын татвар, төлбөр төлөх иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг маягтаар гаргаж холбогдох газарт хүргүүлэв.

Өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг илрэх бүрт нь арилгах ажил зохион байгуулж байгаа ба үүнтэй холбоотой сумын Засаг даргаар 2 иргэнд өмчлүүлсэн газрын хэмжээнд өөрчлөлт оруулах тухай захирамж гаргуулав.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг хангах зорилгоор нийт 7 иргэнд шинээр газар эзэмшүүлэх тухай захирамж гаргуулав. Газрын тухай хууль зөрчсөн нийт 10 иргэн, ААНБ-уудад гарсан захирамж болон газар эзэмшлийн гэрчилгээг хүчингүй болгох тухай захирамж гаргуулж газар чөлөөлүүлэх ажил зохион байгуулав.

Нийт 6 иргэн, ААНБайгууллагад шинээр газар эзэмшлийн гэрчилгээ бичиж гэрээ байгуулав. Газар өмчлөлийн гэрчилгээ авахаар хандсан 4 иргэнд сумын Засаг даргын захирамж, хянан баталгаа, кадастрын зураг гэх зэрэг холбогдох бичиг баримтуудыг нь бүрдүүлж өгсөн.

Дөрөв. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Татварын орлого 2019 оны эхний 5 сарын байдлаар төлөвлөгөө 20,181.9 мянган төгрөгөөс гүйцэтгэл 25,176.9 мянган төгрөг буюу 124,75 хувиар давж биелэгдсэн.

Тав. Хөдөө аж ахуйн талаар

Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2020 он хүртэлх үйл ажиллагааны төлөвлөгөөг сумын түвшинд боловсруулж батлуулан ажиллаж байгаа. Төлөвлөгөөнд 24 төрлийн ажил төлөвлөж үүнээс сумын хэмжээнд 14 төрлийн ажил хэрэгжиж байна.

Малжуулах хөтөлбөрийн хүрээнд 2019 онд 11 залуу малчин хамрагдаж нийт 50 сая төгрөгийн малыг худалдан авч өгсөн болно.

Эцэг малыг хээлтүүлгийн бус үед ялган суурилуулах ажлыг 5 дугаар сараас эхэлж зохион байгуулж байна.

2019 оны хагас жилийн байдлаар сум хөгжүүлэх сангийн зээлд хамруулахаар хүсэлт гаргаж, төсөл бичсэн 9 иргэнээс шаардлага хангасан 6 иргэнийг сонгон 29 сая төгрөгийн зээл олгосон.

2019 оны хагас жилд сумын хэмжээнд 3066 ширхэг арьс, шир бэлтгэж баримтыг программд оруулж, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

7. ЦАГААННУУР ТОСГОН

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр тосгоны эмзэг бүлгийн болон бүтэн өнчин, хагас өнчин, нэн ядуу өрхийн 36 хүүхдүүдэд гарын бэлэг өгөв. Мөн Алдарт эх одонгоор шагнуулсан ээжүүдийн одонг гардуулан өгөв.

Хүүхэд үрчлэхтэй холбоотой харилцаанд хүүхдийн эрхийг хамгаалах нь, Аймгийн төрийн албан хаагчдын манлайллын чадварыг бэхжүүлэх нь, ХАБЭАхуйн сургалт, Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг, Төрийн захиргааны байгууллагын удирдах

албан тушаалтнуудын сургалт, Цэргийн бэлтгэл сургалтуудад холбогдох албан тушаалтнууд оролцов.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг угтаж аймгаас ажлын хэсэг 6 дугаар сарын 12-нд ирж ажиллан, тосгоны төсвийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг шалган зөвлөв. Урьдчилсан үзлэгээр тосгоны албан байгууллагууд “Хангалттай” үнэлгээтэй гарсан.

Захирагчийн албанаас гарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилт, “Эрүүл зан үйлийг дэмжсэн архидалтгүй аймаг-Баян-Өлгий” дэд хөтөлбөрийн явцын биелэлт, эрх зүйн ажлын болон нотариатын хагас жилийн тайланг гаргаж хүргүүлэв.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг танилцуулах УИХ-ын ажлын хэсгийн гишүүн Г.Солтан, аймгийн ИТХ-ын дарга Д.Бауыржан бусад ажлын хэсгийн гишүүд Цагааннуур тосгонд 6 дугаар сарын 20-нд ирж иргэдийн саналыг сонсож ажиллаа.

Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын талаар

1. Хилийн 0285-р анги	Үндсэн цалин	-	238,264,436.00 төгрөг
2. Дунд Сургууль	Үндсэн цалин	-	70,342,172.00 төгрөг
3. Хүүхдийн Цэцэрлэг	Үндсэн цалин	-	38,260,052.00 төгрөг
4. Эрүүл мэндийн төв	Үндсэн цалин	-	16,032,800.00 төгрөг
5. Соёлын төв	Үндсэн цалин	-	4,200,500.0 төгрөг
6. Захирагчийн алба	Үндсэн цалин	-	10,076,800.00 төгрөг
Бүгд			377,176,760.00 төгрөг

Гурав. Статистик мэдээний талаар

Том малын зүй бус хорогдлын мэдээ:	- Төллөсөн хээлтэгч	- 12035
Үүнээс	- Гарсан төл	- 12035
	- Хорогдсон төл	- 399
	- Бойжсон төл	- 11636
Том малын зүй бус хорогдлын мэдээ	- Хорогдсон том мал	- 328
	- Өвчнөөр хорогдсон	- 204
	- Хорогдсон хээлтэгч	- 124

Дөрөв. Боловсрол, соёлын талаар

Захирлын тушаалаар батлагдсан улсын шалгалтын комисс хуваарийн дагуу шалгалтыг авч дүнг 24 цагийн дотор гаргав. Системд хичээлийн дүнг шивж оруулан судлагдахууны дүнг баталж төгсөлт хийв.

5-р ангиас нийт 4 шалгалт, 9-р ангиас нийт 5 шалгалт авагдаж дүнгийн шивэлт хийгдэв.

Багш нар цахим журналаа системд оруулахын зэрэгцээ, жилийн эцсийн дүнгүүдээ шивж оруулан баталгаажуулав. Мөн журнал бичиг баримтаа тушааж дуусгав.

Эх үрсийн баярыг тохиолдуулан тосгоны төвийн цэцэрлэгийн өглөөлөгийг 2019 оны 5-р сарын 29-ний өдөр, Улаанбайшинтын салбар бүлгийн өглөөлөгийг 5-р сарын 30-ны өдөр тоглуулав.

Аймгийн БСУГ-аас багш нарын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж бие биенээсээ суралцах зорилгоор зохион байгуулсан тэргүүлэх зэрэгтэй багш нарын зөвлөгөөнд тосгоны багш нар оролцов.

Тав. Эрүүл мэндийн талаар

Бүх үзлэг	-	328
-Урьдчилан сэргийлэх үзлэг	-	91
-Амбулаторийн үзлэг	-	87
-Гэрийн дуудлагын тоо	-	29
-Алсын дуудлага	-	12
-Нас баралт	-	1
-Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн	-	4
-Эмнэлгээс эмчлүүлж гарсан	-	4
-Аймагт төрсөн эх	-	2
-Өөрийн эмнэлэгт төрсөн	-	0
-Аймагт шилжүүлсэн жирэмсэн эх	-	3
-Хяналтад байгаа жирэмсэн эх	-	20
-Шинээр хяналтад авсан жирэмсэн эх	-	1
- Дархлаажуулалтад	-	20 иргэн тус тус хамрагдсан байна.

Зургаа. Улсын бүртгэлийн талаар

Улсын бүртгэлийн 8 төрлийн бүртгэлд:

-Төрөлт	-	1
-Нас баралт	-	0
-Шилжин ирсэн	-	2
-Тараасан цахим үнэмлэх	-	4
-Цахим үнэмлэх шинээр	-	1
-Цахим үнэмлэх сунгалт	-	1 тус тус бүртгэгдсэн болно.